

"ӨГИЙ ЦОМ - 2024" ЭРЭГ ДЭЭРЭЭС ХИЙМЭЛ ӨГӨӨШӨӨР МАХЧИН ЗАГАС БАРИХ НЭЭЛТТЭЙ ТЭМЦЭЭНИЙ ДҮРЭМ

НЭГ. ЗОХИОН БАЙГУУЛАЛТ


- 1.1. Тэмцээнд оролцох баг нь **4 тамирчинтай** байх ба 1 нөөц тамирчинтай байж болно. Үндсэн 4 тамирчны нэг нь багийн ахлагч байна. Мөн баг нь 1 багийн менежертэй (дасгалжуулагч) байж болно.
- 1.2. Тэмцээний явцад гарах аливаа гэмтэл, гэнэтийн зүйлийн улмаас тамирчин нь солигдох шаардлага гарсан тохиолдолд албан ёсны мэдүүлгээр тодорхойлогдсон нөөц тамирчныг, загасчлах хэрэгслийн хамт солих боломжтой. Тамирчин солигдох үйл ажиллагаа ерөнхий шүүгчийн хяналтад явагдана.
- 1.3. Загасчлал бүхэлдээ **сэртэнгүй дэгээтэй, хиймэл өгөөшөөр бариад тавих** зарчмаар явагдана.
- 1.4. Тэмцээний явцад барьсан загасаа буцаан тавих үүргээ биелүүлээгүй аливаа тамирчин аваргын шагналыг хүртэх эрхгүй байна. (Загас алахыг хориглоно)
- 1.5. Тэмцээн болох нууран дээр **А, В, С, D** гэсэн **4 сектор**т хуваасан хил хязгаарыг тууз, хашлагаар тогтоох ба зөвхөн багийн менежер (дасгалжуулагч) л сектор хооронд нэвтрэх эрхтэй байна.
- 1.6. Сектор бүрд өрсөлдөж байгаа багийн тооноос **2 дахин их** тооны хайрцаг (блок) байна. Байрлалын эрэмбэ нь нуурын урсгалын хамгийн доороос эхэлнэ. Жишээ нь: 10 баг = 20 хайрцаг, 15 баг оролцож байгаа бол 1-ээс 30 хүртэл дугаарлагдсан 30 хайрцагтай байна.
- 1.7. Тэмцээний хэсэг нь тамирчдад **хуурай эрэг дээрээс загасчлах** боломж олгохуйц байх ёстой. Хэрэв загасчлах хэсэгтээ хүрэхийн тулд зайлшгүй ус туулах шаардлагатай хэсэг таарвал тэр хэсгийг тэмцээний орчноос хасах хүртэл арга хэмжээг зохион байгуулагчид авна.
- 1.8. Тамирчдын загас барих орчин нь үзэгч, ажиглагчдаас тууз, хашлагаар ойлгомжтойгоор тусгаарлагдсан байна. (Хамгийн багадаа 10 метр зайтай байна)
- 1.9. Тэмцээнд оролцох **нэг багийн хураамж нь 700,000 төгрөг** байх ба үүнд загасчлах эрхийн төлбөрийг багтаасан байна. (Багийн үндсэн 4 гишүүнтэй)
- 1.10. Нэг клубээс нэг буюу түүнээс дээш баг бүрд гүүлж оролцож болно.
- 1.11. Зохион байгуулагчийн зүгээс тэмцээний орчны гол хэсэгт баг бүрийн нэрийг бичиж, тэмцээний явцын дүнг мэдээлэх **самбар** байрлуулна. Тэмцээний үе бүрд барьсан загасны тоог тухайн баг бүрийн ард тэмдэглэнэ.

ХОЁР. ТЕХНИКИЙН ЗӨВЛӨГӨӨН БА БАГИЙН АХЛАГЧ, МЕНЕЖЕРҮҮДИЙН ХУРАЛ

- 2.1. Хуралд багуудын ахлагч, менежерүүд (дасгалжуулагч), ерөнхий шүүгч болон ерөнхий зохион байгуулагч нарыг оролцуулна. Хэрэв аль нэг багийн ахлагч, менежер (дасгалжуулагч) хуралд оролцоогүй тохиолдолд шүүгч нар түүнийг орлон дугаарлалт тогтоох ажиллагаанд оролцоно.
- 2.2. Багийн ахлагч, менежерүүдийн хурлыг (техникийн зөвлөгөөн) тэмцээн болохоос 1-ээс доошгүй өдрийн өмнө хийх ба тэмцээний бүрд гэлийг үүнээс өмнө хаасан байна. Хурлыг цахимаар явуулж болно. Энэхүү хурлаар дараах зүйлсийг танилцуулж, шийдвэрлэнэ:
 - Тэмцээний дүрмийг танилцуулна.
 - Багуудыг танилцуулна.
 - Тэмцээний явцын талаарх мэдээлэл өгнө.
 - Багийн тамирчдыг А, В, С, D гэсэн 4-н секторт хуваарилах сугалааг явуулна.
 - Багийн ахлагч, багийн тамирчин бүрийн арын дугаарыг хүлээн авна.

ГУРАВ. ҮНДСЭН ДҮРЭМ

- 3.1. Тэмцээнд оролцогчид нь тэмцээн болох газарт өөрийн унаагаар ирнэ. Мөн хоол хүнсээ өөрсдөө авч ирнэ. Байрлах газар өөрсдөө хариуцна.
- 3.2. Тамирчид бие биеэ хянахгүй зөвхөн шүүгчид хянах ба сектор бүрд **1 секторын шүүгч, 4 хүртэлх шүүгч** байна. Хянагч болон ерөнхий хянагч нь тэмцээний дүрмийн талаар бүрэн мэдлэгтэй байна.
- 3.3. Шүүгч нар нь:
 - Тамирчдын дүрмээ баримталж буй эсэхийг хянана.
 - Барьсан загас бүрийг тогтоосон доод хэмжээнд хүрч буй эсэхийг нь хэмжиж шалгана. Энэхүү доод хэмжээ нь тэмцээнийг зохион байгуулж буй газрын онцлогоос хамаарч тогтоогдох ба багийн ахлагч, менежерүүдийн хурлаар **загасны доод хэмжээг** мэдэгдсэн байна.
 - Загас барьж тэр нь доод хэмжээндээ хүрч байвал тамирчид тэр бүрд нь барьсан загасаа амьдруулагч торонд байлгана.
 - Тамирчин бүр хэрэглэх амьдруулагч торт өөрсдөө бэлдэж ирэх үүрэгтэй. Хайрцагт шилжих бүрдээ амьдруулагч тороо авч шилжинэ. Амьдруулагч торны бүрэн бүтэн байдлыг тамирчид өөрсдөө хариуцна. **Амьдруулагч торгүй тамирчныг оролцуулахгүй болно.**
 - Тамирчин нь өрсөлдөгчдийнх нь барьсан загас доод хэмжээнд хүрч буй эсэхэд хяналт тавих эрхтэй.
 - Шүүгч нь үе болгоны төгсгөлд тамирчин бүрийн барьсан загасыг хянаж, хэмжиж, нийт тоог гаргана.
 - Шүүгч нь тэмцээний дэд үе, үе бүрийн төгсгөлд тамирчдын хамт секторын голд ирж барьсан загасны бүрд гэлийг баталгаажуулна. Сектороос гарахын өмнө тамирчин тэрхүү бүрд гэлийг зөвшөөрч цаасан дээр **гарын үсгээ** зурна. Энэхүү бичиг баримт дээр гарын үсэг зурсан бол тухайн үеийн загасны бүрд гэлд гомдол гаргах эрхгүй болно.
- 3.4. Тамирчид өөрийн харьяалагдах секторын голд тэмцээн эхлэхээс дор хаяж **20 минутын** өмнө ирсэн байна.
- 3.5. Тэмцээн дууссаны дараа загасчлалын утас болон өгөөшөө усан дотор эсвэл загасчлалын бүсэд үлдээхийг хориглоно.
- 3.4. Тэмцээн нийт 2 өдөр зохиогдоно. Тамирчид эхний өдрийн үдээс өмнө болон үдээс хойш гараанд гарна. Дараагийн өдөр зөвхөн үдээс өмнө гараанд гарна.
- 3.5. Тэмцээн нь үндсэн **3 үеэр** явагдах ба үе тус бүр нь **45 минутаас бүрдэх 4 дэд үетэй** байна. Давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалан тэмцээн зогссон бол тухайн дэд үе хамгийн багадаа 15 минут үргэлжилсэн тохиолдолд хүчинтэйд тооцно.
- 3.6. Тэмцээнд зөвхөн хиймэл өгөөшийг зөвшөөрөх (**халбага, воблер, уян резин**) ба ялаа болон шавж (флайн загасчлалын өгөөшнүүд) зөвшөөрөхгүй. Мөн өгөөшний дэгээ болон бусад хэсэгт ямар нэг төрлийн **үс, өд, утас байхыг зөвшөөрөхгүй**. Бүх төрлийн өгөөшинд **сэртэнгүй** дэгээг ашиглана.
- 3.7. Доорх зурагт үзүүлсэн сольдог болон цаанаасаа суурилсан хоёр хувилбарыг зөвшөөрнө. Утсанд нэмэлт хүндрүүлэгч хэрэглэхийг хориглоно.



- 3.8. Утас салаалагч ашиглахыг хориглоно. Хиймэл өгөөш нь нэг, хоёр, гурван салаа дэгээтэй байж болох ба **сэртэнгүй** байх ёстой. Өгөөш болон дэгээг загас барьсанд даруйд шалгаж болно.
- 3.9. Өгөөшийг усанд каст хийсний дараа сул гар дамрын бариул дээр байх ёстой. Утсыг зөвхөн уурганы биетэй хамт барихыг зөвшөөрнө. Утсыг дангаар нь татаж барихыг хориглоно.

- 3.10 Нуурын **бүх төрлийн загасыг тооцно**.
- 3.11 Санаатайгаар загасны их биеэс сүлбэж барихыг хатуу хориглоно.
- 3.12 Тамирчид хэдэн ч уурга авч ирэхийг зөвшөөрөх боловч тэмцээний тухайн агшинд зөвхөн **1 уурга** хэрэглэнэ. Уурганд бусад тоноглолыг хийж бэлдсэн байхыг зөвшөөрнө.
- 3.13 Тамирчид гадны тусламж авах хориотой. Зөвхөн багийн менежер загасчилж буй хэсэгт нэвтрэх эрхтэй боловч зөвхөн **амаар зөвлөгөө** өгөх эрхтэй.
- 3.14 Загасчлалын уурга хамгийн уртдаа **2.75 метр** байна (9 feet).
- 3.15 Тэмцээний дохио:
- (1-р дэд үе):**
- 1-р сигнал:** Энэ нь тамирчдад тэмцээн эхлэхэд **20 минут** дутуу байгааг мэдээлнэ. Энэ хугацаанд тамирчин өгөөш, материалаа бэлдэхээс гадна сектороо судалж болно.
- 2-р сигнал:** Тамирчид секторынхоо голд цугларах ба сугалж тогтсон дарааллын дагуу загасчлах хэсгээ чөлөөтэй байгаа хайрцгуудаас өөрөө сонгоно. Тамирчид **30 секунд**ийн давтамжтайгаар явах бөгөөд энэхүү явах дарааллыг секторын ерөнхий хянагч сугалж явуулна. Энэ сигналын дараа өгөөш өгч авалцах нь хориотой болно.
- 3-р сигнал:** Загасчилж эхлэх дохио, үргэлжлэх хугацаа **45 минут**
- 4-р сигнал:** Тамирчид **загас барихаа зогсоох** бөгөөд секторын голд цуглана. Энэ удаад автомат хуваарилалтын дарааллаар тамирчид загасчлах хайрцгаа сонгоно. 30 секундийн давтамжтайгаар загасчид загасчлах газар луугаа гарна.
- (2-р дэд үе):**
- 5-р сигнал:** Загасчилж эхлэх дохио, үргэлжлэх хугацаа **45 минут**
- 6-р сигнал:** Тамирчид загас барихаа зогсоох бөгөөд секторын голд цуглана. Автомат хуваарилалтын дарааллаар тамирчид загасчлах хайрцгаа сонгоно.
- (3-р дэд үе):**
- 7-р сигнал:** Загасчилж эхлэх дохио, үргэлжлэх хугацаа **45 минут**
- 8-р сигнал:** Тэмцээний тухайн үе **өндөрлөнө**.
- (4-р дэд үе):**
- 9-р сигнал:** Загасчилж эхлэх дохио, үргэлжлэх хугацаа **45 минут**
- 10-р сигнал:** Тэмцээний тухайн үе **өндөрлөнө**.
- 3.16 Загасчилж эхлэх дохио өгсний дараагаас л тамирчид чөлөөтэй хайрцаг хооронд явж, сонгох, загасчлах эрхтэй.
- 3.17 Тэмцээний хэсэг, үе бүрийн төгсөх дохио өгөх агшин бүрд **газардуулах торонд орсон** загасыг л барьсанд тооцно.
- 3.18 Тэмцээний үед авианы буюу загас илрүүлэх төхөөрөмж ашиглахыг хориглоно. Мөн тэмцээний явцад тамирчид чихэвч болон богино долгионы станц хэрэглэхийг хориглоно.
- 3.19 Загасанд тэжээл өгөх, хооллох, загасны сонирхлыг татах бодис хэрэглэхийг хориглоно.
- 3.20 Загасчлах явцад голын **усанд туулж орохыг**, усан дотроос загасчлахыг хориглоно. Тамирчид зөвхөн хуурай эрэг дээрээс загасчлах үүрэгтэй. (Дэгээгээ занганд зоосон тохиолдолд утсыг таслах ба зөвхөн тэмцээн дууссаны дараа ус руу орж авч болно)
- 3.21 **Архи болон согтууруулах ундаа хэрэглэсэн тамирчны багийг тэмцээнд оруулахгүй. Мөн тэмцээний явцад хэрэглэхийг хатуу хориглоно /Хатуу баримтална/.**

ДӨРӨВ. ЗАГАС БАРИХ, БАРЬСАН ЗАГАСЫГ ШАЛГАХ

- 4.1. Загасыг зөвхөн **газардуулах тор** ашиглан уснаас гаргах бөгөөд торонд оруулах үйлдэл усан дотор явагдах ёстой.



- 4.2. Дараах аргаар барьсан загасыг тооцохгүй:
- Загасыг уснаас **чирч гаргасан**, газардуулсан бол
 - Торонд тусгаарлахаас өмнө загас дэгээнээс **мултарч газарт** унасан бол
 - Загасыг амьдруулагч торонд хийхээс өмнө **газарт хүргэсэн** бол
 - Аль нэг торны **нүхээр** болон торноос давж **газарт** унасан бол
- 4.3. Загас дэгээг **амаараа үмхээгүй ба толгойн хэсгээс хойш сүлбэсэн** бол загасыг барьсанд тооцохгүй ба шууд буцаан тавих ёстой.
- 4.4. Хэрэв загас дэгээг хэт гүн залгиж, түүнийг салгах боломжгүй болсон тохиолдолд шүүгчийн зөвшөөрлөөр **утсыг таслан**, загасыг буцаан тавина. Энэ тохиолдолд оноог тооцно.
- 4.5. Барьсан загас доод хэмжээний шалгуурт тэнцэх эсэхийг шүүгч загас хэмжих хэрэгслийг ашиглан хэмжинэ. Хэмжилт нь шулуун байрлалтай загасны уруулаас сүүлний аль илүү урт төгсгөл хүртэл хийгдэх ба доод хэмжүүртэй тэнцүү ба давсан хэмжээтэй загас тооцогдоно.
- 4.6. Тамирчин нь өөрт ногдсон талбай дотроо чимээ багатай, болгоомжтой явна.
- 4.7. **Зэргэлдээ тамирчны** загасчлах хэсэгт өгөөш шидэхийг хориглоно. Мөн зэргэлдээ тамирчны хэсгээс барьсан загасыг тооцохгүй.
- 4.8. Тэмцээнд оролцогчид тухайн тэмцээнд хүчин төгөлдөр дүрэмд заагдсан загасны зөвшөөрөгдсөн хэмжээ (**15см-ээс дээш**) хязгаарыг баримтална. Эдгээр хэмжээнүүд хурал дээр танилцуулагдсан байх ёстой.

ТАВ. ШИЙТГЭЛҮҮД

- 5.1. Дүрмийн 3.10, 3.13, 4.6, 4.7 заалтуудыг 2-р ба түүнээс дээш удаа зөрчвөл сануулга шар картаар торгоно.
- 5.2. Дүрмийн 1.3, 1.4, 3.5, 3.6, 3.7, 3.8, 3.9, 3.10, 3.11, 3.12, 3.14, 3.16, 3.18, 3.19, 3.20, 3.21 заалтуудыг зөрчих, мөн 5.1-д заасан зөрчлийг давтан гаргавал буюу 2 шар хуудас авбал тэмцээний эрх хасах улаан картаар торгоно.
- 5.3. Эрх хасагдсан тамирчин тэмцээний бүх үед оролцох эрхгүй болох ба нөөц тамирчин оруулах эрхгүй байна.
- 5.4. Хэрэв тамирчин эрхээ хасуулсан бол тэмцээнд оролцож буй багийн нийт тоон дээр 1-ийг нэмсэн дүнгээр шийтгэлийн оноо авна. Оноо тооцох үед хасагдсан тамирчны дараагийн байранд байсан тамирчин түүний авах ёстой байсан оноог авна. Жишээ: 8-р байранд байсан тамирчны эрх хасагдсан бол түүний ард жагсаж байсан тамирчид 1 байраар урагшилна.
- 5.5. Хэрэв оролцогч тамирчин сануулга авбал 2 жилийн хугацаанд хүчинтэй байна.
- 5.6. Зохион байгуулах комисс нь тэмцээний явцад тамирчин, багийн ахлагч, орлох тамирчны гаргах аливаа дүрмийн бус үйлдэл, буруу биеэ авч яваа байдалд үнэлэлт дүгнэлт өгч, шийдвэр гаргах эрхтэй.

ЗУРГАА. ДҮН ГАРГАЛТ

6.1. Сектороор дүгнэх:

Сектор бүрд үе бүрийн 4 дэд үеийн туршид дараах хэлбэрээр дүнг гаргана:

- Хамгийн олон загас барьсан тамирчнаас эхлэн 1-ээс эхлэн оноо өгнө.
- Хэсэгт оноо тэнцсэн тохиолдолд оноог дундажлах замаар өгнө. (Жишээ нь хоёр тамирчин 4-р байранд тэнцсэн бол $(4+5):2=4.5$ оноог тус бүрд нь өгнө. Гурван тамирчин тэнцсэн бол $(6+7+8):3=7$ оноо тус бүрд өгнө.)
- Нэг ч загас бариагүй тамирчин тухайн хэсэгт загас бариагүй бусад тамирчинтай сүүлийн оноонуудыг дундажлан хувааж авна. (Жишээ нь: 13 тамирчин өрсөлдсөнөөс эхний 8 тамирчин загас барьж тооцуулсан гэж үзвэл үлдсэн тамирчид $(9+13):2=11$ оноог тус бүр авах юм.) Хэрэв цорын ганц тамирчин ямар ч загас бариагүй бол сүүлчийн байрлалын дугаартай тэнцүү оноо авна. Манай жишээгээр бол 13 оноо авна.

Секторын тухайн үеийн нийлбэр дүнг дараах байдлаар гаргана:

- Хамгийн бага оноо авсан тамирчин нь нэгт эрэмбэлэгдэнэ. (4 дэд үеийн турш авсан оноонуудын нийлбэрээр)
- Тэнцсэн тохиолдолд барьсан загасны нийлбэр тоогоор байр эзлүүлнэ.
- Хэрэв тэр нь тэнцвэл тухайн тамирчны хамгийн олон загас барьсан үеийн загасны тоогоор эрэмбэлнэ.
- Тэнцээ арилахгүй бол хамгийн бага оноо авсан хэсгийн оноогоор эрэмбэлнэ.
- Тэнцээ арилахгүй бол байрыг дундажлан хувааж эзэлнэ.

6.2. Багийн дүн:

- Нэг багийн гишүүн бүрийн секторт эзэлсэн байрын нийлбэрийг үе бүр дээр гаргаж, багаас нь эхлэн эрэмбэлнэ.
- Тэнцвэл хамгийн бага оноо авсан баг нь нэгт эрэмбэлэгдэнэ. (Хоёр үеийн турш авсан оноонуудын нийлбэрээр)
- Тэнцсэн тохиолдолд багуудын тухайн үеийн турш барьсан загасны нийлбэр тоогоор байр эзлүүлнэ.
- Хэрэв тэр нь мөн л тэнцвэл багийн хамгийн олон загас барьсан үеийн загасны тоогоор эрэмбэлнэ.
- Тэнцээ арилахгүй бол сүүлийн хэсгийн загасны нийлбэр тоогоор байр эзлүүлнэ.
- Тэнцээ арилахгүй бол тухайн үе дээр байрыг дундажлан хувааж эзэлнэ.

1-р үе Нийлбэр			Хамгийн их	Сүүлийн хэсэг	1-р үе	2-р үе Нийлбэр			Хамгийн их	Сүүлийн хэсэг	2-р үе
Байр ¹	Оноо ²	Тоо ³	Тоо ⁴	Тоо ⁵	Байр	Байр ¹	Оноо ²	Тоо ³	Тоо ⁴	Тоо ⁵	Байр

- Багийн эцсийн дүнг **3 үеийн** нийлбэр оноогоор дараах дарааллын дагуу дүгнэж гаргана.

Нийт			Хамгийн их	Сүүлийн үе	Эцсийн
Байр ¹	Оноо ²	Тоо ³	Тоо ⁴	Тоо ⁵	Байр

6.3. Хувийн дүн:

- Тамирчин бүрийн үе бүр дээр эзэлсэн байраар жагсааж, үе бүр дэх хувийн байрыг гаргана.
- Байр нь тэнцвэл нийлбэр оноогоор эрэмбэлнэ. Хамгийн бага оноо авсан оролцогч хувийн дүнгээр эхэлж эрэмбэлэгдэнэ.
- Оноо тэнцсэн тохиолдолд тухайн үеийн турш хэн илүү олон загас барьсан нийлбэр дүнгээр эрэмбэлнэ.
- Хэрэв тэр нь мөн л тэнцвэл хамгийн олон загас барьсан хэсгийн загасны тоогоор эрэмбэлнэ.
- Тэнцээ арилахгүй бол сүүлийн хэсгийн загасны тоогоор эрэмбэлнэ.
- Тэнцээ арилахгүй бол хамгийн бага оноотой дэд үеийн оноогоор эрэмбэлнэ.
- Тэнцээ арилахгүй бол тухайн үе дээр байрыг дундажлан хувааж эзэлнэ.

1-Р ҮЕ ХУВИЙН ДҮН

2-Р ҮЕ ХУВИЙН ДҮН

Сектор		Нийт			Хамгийн их	Сүүлийн хэсэг	Хамгийн бага	Байр	Сектор		Нийт			Хамгийн их	Сүүлийн хэсэг	Хамгийн бага	Байр
1-р үе	Байр ¹	Оноо ²	Тоо ³	Тоо ⁴	Тоо ⁵	Оноо ⁶	2-р үе		Байр ¹	Оноо ²	Тоо ³	Тоо ⁴	Тоо ⁵	Оноо ⁶			

- Хувийн эцсийн дүнг **3 үеийн** нийлбэр оноогоор дараах дарааллын дагуу дүгнэж гаргана.

НИЙЛБЭР ХУВИЙН ДҮН

Оролцсон үеийн тоо ¹	Нийлбэр			Хамгийн их (үе) Тоо ⁵	Сүүлийн үе Тоо ⁶	Эцсийн Байр
	Байр ²	Оноо ³	Тоо ⁴			

- 6.4. Тэмцээний үр дүн болон бусад зүйл дээр тэмцээн дууссанаас хойш 1 цагийн дотор гомдол гаргах эрхтэй. Гомдлыг хэдий амаар гаргаж болох боловч бичгийн хэлбэрээр албан ёсоор хүлээн авна. Гомдлыг гаргахдаа шалгалтын комисст 50,000 төгрөгийн төлбөр төлөх ба шалгалтын комисс шалгаж үзээд гомдлыг хүлээн аваагүй байсан ч энэхүү төлбөрийг буцаан олгохгүй болно.

ДОЛОО. ШАГНАЛ

7.1 Багийн дүн

- Нэгдүгээр байр: Аваргын цом, Алтан медаль, Өргөмжлөл, 5 сая төгрөг
- Хоёрдугаар байр: Цом, Мөнгөн медаль, Өргөмжлөл, 3.5 сая төгрөг
- Гуравдугаар байр: Цом, Хүрэл медаль, Өргөмжлөл, 2 сая төгрөг

7.2 Хувийн дүн

- Нэгдүгээр байр: Авирмэдийн нэрэмжит Цом, Алтан медаль, Өргөмжлөл, 2.5 сая төгрөг
- Хоёрдугаар байр: Цом, Мөнгөн медаль, Өргөмжлөл, 2 сая төгрөг
- Гуравдугаар байр: Цом, Хүрэл медаль, Өргөмжлөл, 1.5 сая төгрөг

7.3 Тусгай байр, шагнал

- Хамгийн том алгана загас: Ивээн тэтгэгчийн шагнал
- Хамгийн том цурхай загас: Ивээн тэтгэгчийн шагнал
- Хамгийн олон загас: Ивээн тэтгэгчийн шагнал
- Хамгийн залуу тамирчин: Ивээн тэтгэгчийн шагнал
- Хамгийн ахмад тамирчин: Ивээн тэтгэгчийн шагнал
- Хамгийн өндөр амжилттай шинэ баг, клуб: Ивээн тэтгэгчийн шагнал
- Сугалааны шагнал